



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Дүүргийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/96 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн зарим гишүүдийн харьяалагдах байгууллагын нэршил өөрчлөгдсөн мөн татан буугдсан, зайлшгүй хэрэгцээтэй албан тушаалтныг нэмж оруулах шаардлагатай ,болсон тул дүүргийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

2.“Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.“Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн дүрмийг холбогдох хууль, эрх зүйн акт, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс (Б.Өлзийбат)-д даалгасугай.


4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2017 оны А/94 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 04 сарын 14-ны өдрийн 1167 дугаар
захирамжийн хавсралт



ДҮҮРГИЙН "ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ"-ИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийн төлөө зөвлөлийн
дэд дарга:

Гишүүд:

Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн
асуудал хариуцсан орлогч
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн
дарга бөгөөд Ажлын албаны дарга
Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа,
үйлчилгээний хэлтсийн дарга
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Дүүргийн статистикч
Эрүүл мэндийн төвийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Цагдаагийн хэлтсийн дарга
Онцгой байдлын хэлтсийн дарга
Соёлын ордны захирал
Биеийн тамир, спорт хорооны дарга
"Хангай" цогцолбор сургуулийн захирал
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн
дарга
"Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын захирал
"Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж"
ОНӨААТҮГ-ын захирал
Дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
холбооны тэргүүн
Дүүргийн Улаан загалмайн хорооны дарга
Дүүргийн хүүхдийн зөвлөлийн тэргүүн

Нарийн бичиг:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн
дарга